



**“СҮЛД-АУДИТ” ХХК**

# **ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН**

**“ХҮРД” ХК**

*2024 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар  
болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан*

Улаанбаатар хот

2025 он



**Нэмэлт мэдээлэл авахыг  
хүсвэл дараахь хаягаар  
харилцана уу:**

“СҮЛД-АУДИТ” ХХК

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот,  
Сүхбаатар дүүрэг, Бага тойруу  
8-р хороо, 11-р хороолол  
GB center 502 тоот

Утас: 70118016

Web: [www.suld-audit.mn](http://www.suld-audit.mn)

Захирал: Ч.Гүндбаяр

Утас: 99114056

e-mail: [info@suld-audit.mn](mailto:info@suld-audit.mn)

**Аудиторууд:**

Ч. Гүндбаяр

С. Лхагважав

Г. Төрсайхан

**ХҮРД ХК  
2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН  
ТАЙЛАН**

**АУДИТЫН ДУУСГАВАР БОЛГОСОН  
ТУХАЙ ТАЙЛАН**

АГУУЛГА	ХУУДАС
1. Байгууллагын талаарх мэдээлэл	1
2. Удирдлагын хариуцлагын захидал	2
3. Хараат бус аудиторын тайлангийн дүгнэлт	3
4. Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	5
5. Удирдлагад хүргэх захидал	9
6. Аудиторын тайлангийн тодруулга	10
7. Санхүүгийн тайлангийн тодруулга	14
8. Удирдлагад өгөх зөвлөмж	18

**“ХҮРД” ХУВЬЦААТ КОМПАНИ**

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн тайлан  
**БАЙГУУЛЛАГЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**

**Байгуулах шийдвэр:** Хүрд ХК нь 1996 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор хувьцаат компанийн хэлбэрээр байгуулагдсан. 2061783 тоот регистрийн дугаар бүхий 9010001054 дугаартай Улсын бүртгэлийн гэрчилгээ авсан байна.

**Үндсэн үйл ажиллагаа:** Барилга угсралтын ажил

**Гүйцэтгэх захирал:** Э.Тэмүүжин

**Ерөнхий нягтлан бодогч:** Б.Сумъяа

**Ажиллагсадын тоо**

**Байнгын хаяг:** Монгол улс, Улаанбаатар хот,  
Чингэлтэй дүүрэг, 6-р хороо, Их тойруу  
45-р байр – Өөрийн байр  
Утас: 72720606

**Өмнөх Аудит:** “Бэст Фортуна Аудит” ХХК

**Аудит:** “СҮЛД-АУДИТ” ХХК  
Улаанбаатар хот, Монгол улс  
Сүхбаатар дүүрэг 8-р хороо  
11-р хороолол, Бага тойруу  
Жи-Би центр 502 тоот  
Утас: 976-7011 8016  
И-мэйл: info@suld-audit.mn

(Үйлчлүүлэгч байгууллагын бланк дээр)

**“ХҮРД” ХК-ИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ  
УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ**

Бид Хүрд ХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон санхүүгийн тайлангийн тодруулгын бүх материаллаг үзүүлэлтүүдээр СТОУС болон Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу үнэн зөв бэлтгэн толилуулсан болохыг үүгээр баталж байна.

Мөн санхүүгийн тайлантай холбоотой дараах үүргийг Компанийн удирдлага хүлээнэ.

Үүнд:

- Компанийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв илэрхийлж, санхүүгийн тайлангаа СТОУС-ын дагуу бэлтгэж, толилуулах;
- Нягтлан бодох бүртгэлийг Монгол улсын хууль тогтоомжийн дагуу хөтлөх;
- Тайлант хугацааны санхүүгийн тайланд компанийн үйл ажиллагааны эдийн засаг, санхүүгийн бүхий л үйл явцыг бүрэн бүртгэж тусгах;
- Тайланд тусгагдсан хөрөнгө, түүний эх үүсвэрийг компанийн өмчлөлд бүрэн бүртгэх ба орхигдуулахгүй байх;

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ

A handwritten signature in black ink, appearing to be "Түвшин", written above a horizontal dotted line.



Г ХҮРД ХК-ИЙН ХУВЬЦАА  
ЭЗЭМШИГЧДЭД Т

### СҮЛД-АУДИТ ХХК

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг  
Бага тойруу 8 дугаар хороо, 11-р  
хороолол GB-центр #502 тоот  
Утас:(976) 93098181, 99114056  
E-mail: [info@suld-audit.mn](mailto:info@suld-audit.mn)

2025. 3. 11 № 25/12  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

### Санхүүгийн тайлангийн аудитын тайлан

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Бид "Хүрд" ХК-ийн (цаашид "Компани" гэх) 2024 оны 12 дугаар сарын 31-ээрх санхүүгийн байдлын тайлан, тайлант жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан бүхий санхүүгийн тайлангууд, эдгээр санхүүгийн тайлантай холбоотой нэмэлт тайлбар тодруулга болон нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогуудад аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар "Хүрд" ХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн үйл ажиллагааны орлого үр дүн, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээ нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн Үндэслэл

Бид аудитаа Аудитын олон улсын стандарт (АОУС)-ын дагуу хийсэн. Эдгээр стандартын дагуу хүлээх хариуцлага энэхүү тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан. Бид Монгол Улсын Аудитын тухай хуулиар санхүүгийн тайлангийн аудитад тавигддаг ёс зүйн шаардлагын дагуу ёс зүйн үүрэг хариуцлага бүрэн биелүүлсэн. Бидний олж авсан аудитын баримт нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай, зохистой үндэслэл болно гэж үзэж байна.

#### Асуудлыг Онцгойлсон зүйл

Бид санхүүгийн тайлангийн Тэмдэглэл ё-д компанийн үйлчилгээний байранд гарсан галын үр нөлөөг тодорхойлон түүнд анхаарлаа хандуулж байна. Энэ асуудлын улмаас бид дүгнэлтээ өөрчлөөгүй.

#### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудлууд гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлийн хүрээнд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлсэн асуудлууд байдаг. Эдгээр асуудлыг бид санхүүгийн тайлангийн аудитын агуулгын хүрээнд бүхэлд нь болон энэ тайлангийн талаар аудиторын дүгнэлт гаргахад авч үзсэн бөгөөд аудитор эдгээр асуудлаар тусад нь дүгнэлт өгдөггүй.

### Бусад мэдээлэл

Удирдлага нь бусад мэдээллийн хувьд үүрэг, хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл гэдэгт санхүүгийн тайланд орсон мэдээллийг хамруулж ойлгох ба санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт нь бусад мэдээллийг хамрахгүй бөгөөд үүнд бид ямар нэгэн баталгаажуулалт илэрхийлэхгүй юм.

### Санхүүгийн тайлангийн талаар Удирдлага болон Засаглах удирдлагын хүлээх хариуцлага

Удирдлага нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу бэлтгэж, үнэн зөв шударгаар толилуулах болон залилан юмуу алдаанаас үүдэлтэй материаллаг алдаанаас ангид санхүүгийн тайлан бэлтгэхэд зайлшгүй шаардлагатай тийм дотоод хяналтыг удирдлагаас тодорхойлох үүрэг хариуцлага хүлээнэ.

Санхүүгийн тайлан бэлтгэхдээ удирдлага нь тасралтгүйгээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх, компанийн чадамжийг үнэлж, тодруулах шаардлагатай бол компанийг татан буулгахаар, эсвэл ингэхээс өөр бодит хувилбар байхгүйгээр төлөвлөснөөс бусад тохиолдолд тасралтгүй ажиллагаатай холбоотой асуудал болон нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй ажиллагааны зарчмыг ашиглах үүрэг хариуцлага хүлээнэ. Компанийн засаглах удирдлага нь санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүргийг хүлээнэ.

### Санхүүгийн Тайлангийн Аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Бидний зорилго бол санхүүгийн тайлан нь бүхэлдээ залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй бэлтгэгдсэн эсэх талаар хамгийн боломжит баталгааг олж авах, өөрийн дүгнэлтийг илэрхийлсэн аудиторын тайланг бэлтгэх юм. Хамгийн боломжит баталгаа гэдэг нь дээд түвшний баталгаа боловч АОУС-ын дагуу хийж гүйцэтгэсэн аудит нь оршин байгаа буруу тайлагнал бүрийг үргэлж илрүүлнэ гэсэн баталгааг өгдөггүй. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас гарах бөгөөд хэрэв тэдгээр нь дангаараа болон нийлбэр дүнгээрээ санхүүгийн тайлангуудад үндэслэн хэрэглэгчдийн гаргах эдийн засгийн шийдвэрт ул үндэстэйгээр нөлөөлөх бол материаллаг гэж үзнэ.

### Хэрэглээний хязгаарлалт

Энэхүү тайланг Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 94 дүгээр зүйлд заасан хуулийн этгээд болох хувьцаа эзэмшигчдийн хүсэлтийн дагуу зөвхөн компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

Хүндэтгэсэн,  
Сүлд-Аудит ХХК  
Гүйцэтгэх Захирал, /МНБ/




*Ч.Гүндбаяр*

Ч.ГҮНДБАЯР

**ХҮРД ХК**  
**АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**  
**2024 оны 12-р сарын 31-ний өдрөөрх**

ҮЗҮҮЛЭЛТ	Тод	/төгрөгөөр/	
		12/31/2023	12/31/2024
<b>А. ХӨРӨНГӨ</b>			
<b>1. Эргэлтийн хөрөнгө</b>			
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1	16,242,916,363.98	20,788,463,555.74
Дансны авлага	2	2,180,122,743.16	2,839,356,161.43
Татвар, НДШ-ийн авлага		6,584,978.11	8,806,332.78
Бусад авлага		-	-
Бусад санхүүгийн хөрөнгө	3	5,880,439,127.06	2,740,156,300.83
Бараа материал	4	1,333,134,752.19	1,542,899,953.84
Урьдчилж төлсөн зардал /тооцоо/	5	392,805,276.72	629,978,993.02
Бусад эргэлтийн хөрөнгө	6	5,500,000.00	5,500,000.00
<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>		<b>26,041,50 ,241.22</b>	<b>28,555,161,297.64</b>
<b>2. Эргэлтийн бус хөрөнгө</b>			
Үндсэн хөрөнгө	7	1,699,627,200.83	4,010,758,011.42
Биет бус хөрөнгө	7	279,226.67	202,106.67
<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>		<b>1,699,906,427.50</b>	<b>4,010,960,118.09</b>
<b>НИИТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>27,741,409,668.72</b>	<b>32,566,121,415.73</b>
<b>Б. ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>			
<b>1. Өр төлбөр</b>			
Дансны өглөг	8	3,151,983,854.02	3,570,836,191.79
Цалингийн өглөг		-	-
Татварын өр	8	436,847,615.96	135,856,338.46
НДШ-ийн өглөг		-	-
Хүүний өглөг		-	-
Ногдол ашгийн өглөг	8	17,973,450.26	17,739,074.43
Урьдчилж орсон орлого	8	1,122,801,783.90	1,661,315,598.15
Бусад богино хугацаат өр төлбөр	8	176,356.70	176,356.70
<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>		<b>4,729,783,060.84</b>	<b>5,385,923,559.53</b>
Урт хугацаат зээл		-	-
<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>		<b>-</b>	<b>-</b>
<b>Өр төлбөрийн нийт дүн</b>		<b>4,729,783,060.84</b>	<b>5,385,923,559.53</b>
<b>2. Эздийн өмч</b>			
а. Төрийн		-	-
б. Хувийн	9	1,100,097,785.34	3,550,668,495.34
в. Хувьцаат		-	-
Халаасны хувьцаа		-	-
Нэмж төлөгдсөн капитал		-	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	9	164,937,000.00	164,937,000.00
Эздийн өмчийн бусад хэсэг		-	-
Хуритмлагдсан ашиг, алдагдал	9	21,746,591,822.54	23,464,592,360.86
<b>Эздийн өмчийн дүн</b>		<b>23,011,626,607.88</b>	<b>27,180,197,856.2</b>
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>		<b>27,741,409,668.72</b>	<b>32,566,121,415.73</b>

Хавсаргасан тэмдэглэлүүд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.



**ХҮРД ХК**  
**АУДИТ ХИЙСЭН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН**  
**2024 оны 12-р сарын 31-ний өдрөөрх**

ҮЗҮҮЛЭЛТ	Тод	/төгрөгөөр/	
		12/31/2023	12/31/2024
Борлуулалтын орлого цэвэр)	10	9,749,416,064.79	7,397,906,807.94
Борлуулалтын өртөг	11	6,719,299,608.03	6,953,893,796.37
<b>Нийт ашиг алдагдал)</b>		<b>3,030,116,456.76</b>	<b>444,013,011.57</b>
Түр эсийн орлого	10	117,446,091.73	162,617,165.46
Хүүгийн орлого	10	2,635,512,052.81	2,305,299,588.76
Ногдол ашгийн орлого		-	-
Эрхийн шимтгэлийн орлого		-	-
Бусад орлого	10	142,082,275.04	164,050,100.46
Борлуулалт, маркетингийн зардал		-	-
Ерөнхий ба удирдлагын зардал	12	385,674,020.68	520,263,661.14
Санхүүгийн зардал		-	-
Бусад зардал	13	181,916,871.37	277,795,546.28
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	13	270,069,081.47	-
Үндсэ хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		-	-
Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		-	-
Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		-	-
Бусад ашиг (алдагдал)		-	-
<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>		<b>5,627,635,065.76</b>	<b>2,277,920,658.83</b>
Орлогын татварын зардал	14	580,955,193.71	255,571,620.51
<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>		<b>5,046,679,872.05</b>	<b>2,022,349,038.32</b>
<b>Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)</b>			
<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>		<b>5,046,679,872.05</b>	<b>2,022,349,038.32</b>
<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>			
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэлийн зөрүү			
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү			
Бусад олз (гарз)			
<b>Орлогын нийт дүн</b>		<b>5,046,679,872.05</b>	<b>2,022,349,038.32</b>
<b>Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)</b>			

Хавсаргасан тэмдэглэлүүд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.





**ХҮРД ХК**  
**АУДИТ ХИЙСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**  
 2024 оны 12-р сарын 31-ний өдрөөрх

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуриртлагдсан ашиг	Нийт дүн	/төгрөгөөр/
<b>2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>1,100,097,785.34</b>	<b>164,937,000.00</b>	<b>21,746,591,822.54</b>	<b>23,011,626,607.88</b>	
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			-	-	
<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>1,100,097,785.34</b>	<b>164,937,000.00</b>	<b>21,746,591,822.54</b>	<b>23,011,626,607.88</b>	
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			2,022,349,038.32	2,022,349,038.32	
Бусад дэлгэрэнгүй орлого				-	
Өмчид гарсан өөрчлөлт	2,450,570,710.00			2,450,570,710.00	
Зарласан ногдол ашиг			(304,348,500.00)	(304,348,500.00)	
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				-	
<b>2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>3,550,668,495.34</b>	<b>164,937,000.00</b>	<b>23,464,592,360.86</b>	<b>27,180,197,856.20</b>	

Хавсаргасан тэмдэглэлүүд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.



**ХҮРД ХК**  
**АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**  
 2024 оны 12-р сарын 31-ний өдрөөрх

ҮЗҮҮЛЭЛТ	12/31/2023	/төгрөгөөр/ 12/31/2024
<b>ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>52,856,852,706.47</b>	<b>34,979,367,924.11</b>
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэн орлого	52,586,783,625.00	4,099,891,275.79
Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	-
Буцаан авсан албан татвар	-	-
Татаас, санхүүжилтийн орлого	-	-
Бусад мөнгөн орлого	270,069,081.47	30,879,476,648.32
<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>54,465,296,622.87</b>	<b>27,293,537,906.12</b>
Ажиллагчдад төлсөн	1,174,711,856.56	1,211,916,069.00
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	288,491,991.61	298,332,226.59
Бараа материал худалдан авахад төлсөн	653,023,750.91	705,605,857.69
Ашиг лалтын зардалд төлсөн	58,567,929.29	66,061,587.98
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	74,217,119.98	17,867,203.94
Хүүний төлбөрт төлсөн	-	-
Татварын байгууллагад төлсөн	739,960,861.23	457,968,274.07
Даатгалын төлбөрт төлсөн	39,547,227.22	-
Бусад мөнгөн зарлага	51,436,775,886.07	24,535,786,686.85
<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(1,608,443,916.40)</b>	<b>7,685,830,017.99</b>
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	-	-
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
Хүлээн авсан ногдол ашиг	-	-
<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	-	-
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	-	-
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	-	-
<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	-	<b>1,000,900,000.00</b>
Хувьцаа болон өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	1,000,900,000.00
<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	-	<b>4,141,182,826.23</b>
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-	4,141,182,826.23
Төлсөн ногдол ашиг	-	-
<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	-	<b>3,140,282,826.23</b>
<b>Валютын ханшийн зөрүү</b>		
<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(1,608,443,916.40)</b>	<b>4,545,547,191.76</b>
<i>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</i>	<i>17,851,360,280.38</i>	<i>16,242,916,363.98</i>
<i>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</i>	<i>16,242,916,363.98</i>	<i>20,788,463,555.74</i>

Хавсаргасан тэмдэглэлүүд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.



**УДИРДЛАГАД ХҮРГЭХ ЗАХИДАЛ****ХҮРД ХК-ИЙН  
УДИРДЛАГАД**

“Хүрд” ХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн тайланд аудит хийх явцад бидний анхаарал татсан санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа, дотоод хяналтын системийг сайжруулах тухай асуудлуудыг энэхүү тайланд багтаасан болно.

Санхүүгийн тайлангийн аудитыг Аудитын Олон Улсын Стандарт болон аудитын горимын дагуу хийж гүйцэтгэх явцад бидний анхаарал татсан тодорхой зүйлүүдийг удирдлагад хүргэх зорилгоор аудитын тайланг толилуулав.

“Хүрд” ХК-ийн хэрэгжүүлдэг нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан болно. Санхүүгийн тайланд аудит хийх явцад ажиглагдсан бидний өгсөн зөвлөмжийг анхаарч, хүлээн авч, хэрэгжүүлж ажиллана гэдэгт итгэж байна. Түүнчлэн тайланд бичигдсэн зөвлөмжийн талаар ярилцах, тэдгээрийг хэрэгжүүлэх ажилд туслахад бэлэн байх болно.

Аудитын ажлын явцад бидэнтэй хамтран ажиллаж, туслалцаа үзүүлж байсан “Хүрд” ХК-ийн удирдлага, санхүүгийн ажилтнуудад талархлаа илэрхийлье.

Хүндэтгэсэн,  
Сүлд-Аудит ХХК  
Захирал  
  
Ч. Гүндбаяр МНБ

## 1. Санхүүгийн тайлагналын зарчим

### Нягтлан Бодох Бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй

Тус компани нь санхүүгийн тайлан бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн дараах үндсэн бодлогуудыг баримтладаг.

#### ***а/ Тайлан бэлтгэсэн үндэслэл***

##### **✓ Нягтлан бодох бүртгэлийн ерөнхий суурь**

Тус байгууллагийн санхүүгийн тайлангууд нь нягтлан бодох бүртгэлийг аккурэл суурьд үндэслэн, Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС), Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (НББОУС) болон Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд нийцүүлэн Сангийн яамнаас батлан гаргасан заавар журам, бусад холбогдох хууль тогтоомж аргачлалын дагуу бэлтгэсэн байна. Компанийн тайлагнах валют болох Монгол Улсын мөнгөн тэмдэгт Төгрөгөөр илэрхийлэгдэж, төгрөгөөр харуулж тайлагнагдсан.

##### **✓ Тасралтгүй үйл ажиллагааны зарчим**

Санхүүгийн тайлангууд нь тасралтгүй үйл ажиллагааны зарчимд суурилан бэлтгэгдсэн. Тасралтгүй үйл ажиллагааны зарчмын төсөөлөл хүчинтэй байх эсэх нь компани ирээдүйд тасралтгүй үйл ажиллагаагаа хадгалж чадах эсэхээс хамаарна.

#### ***б/ Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө***

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө нь бэлэн мөнгө болон банк санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгөн хөрөнгөөс бүрдэнэ. Тэдгээрт гарсан мөнгөн хөрөнгийн гүйлгээг тус тусад нь мөнгөн хөрөнгийн журналд тусгадаг байна.

#### ***в/ Гадаад валютаарх ажил гүйлгээ***

Гадаад валютаар гарсан ажил гүйлгээг тухайн өдрийн Монгол банкны албан ханшаар төгрөгт хөрвүүлж төгрөг, валютаар давхар бүртгэдэг. Гадаад валютаар илэрхийлэгдсэн хөрөнгө, өр төлбөрийн мөнгөн зүйлсийг тайлагналын өдрийн хаалтын ханшаар төгрөгт хөрвүүлж илэрхийлдэг. Хөрвүүлэлтээс үүссэн ханшийн зөрүүний олз, гарзыг тайлант үеийн ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрдөг.

#### ***г/ Авлага***

Авлагыг урьдчилан тооцоолсон боломжит үнэ цэнээр нь бүртгэлд тусгадаг. Зээлээр худалдсан бараа бүтээгдэхүүн болон үзүүлсэн ажил үйлчилгээнийхээ төлбөрийг худалдан авагч, бусад харилцагч этгээдээс нэхэмжилж авах мөнгөн дүнг авлагаар тооцож бүртгэдэг.

Гадаад валютаар үүссэн авлагыг гүйлгээ гарсан өдөр мөрдөж буй Монгол банкны албан ханшаар төгрөгт хөрвүүлэн бүртгэлд тусгадаг. Төлбөр хүлээн авсан валютын зарласан ханш нь гүйлгээ гарсан өдрийн ханшнаас хэлбэлзсэн хэмжээгээр ханшийн зөрүү бүртгэдэг байна.

#### ***д/ Бараа материал***

Тус байгууллага нь бараа материалын бүртгэлийн байнгын системийг ашигладаг ба үүний дагуу бараа материалыг худалдаж авсан тухай бүр нь орлого авч, зарлагадах тухай бүр өртөг, зардалд бүртгэдэг байна.

Бараа материалыг өртөг ба цэвэр боломжит үнэ цэний аль багаар үнэлдэг. Бараа материалын өртгийг дундаж өртгийн аргыг ашигладаг бөгөөд бараа материалын өртөгт худалдан авалтын өртөг, хувиргалтын зардал болон одоогийн байршил ба нөхцөлд авч ирэхтэй холбогдон гарсан зардал ордог.

Бараа материалын цэвэр боломжит үнэ цэнэ гэдэг нь бизнесийн хэвийн үйл ажиллагааны явцад борлуулахаар тооцсон үнээс түүнийг борлуулахтай холбоотой гарах зардал болон иж бүрдэл болохтой холбоотой тооцоолсон зардлыг хассан дүн юм.

#### **е/ Урьдчилж төлсөн зардал/ тооцоо**

Үйл ажиллагааны зардлыг зардал гэж хүлээн зөвшөөрөх хүртэл урьдчилж төлсөн зардлаар тайлагнадаг. Урьдчилж төлсөн зардлыг төлсөн хэмжээгээр буюу нэрлэсэн үнээр илэрхийлнэ.

#### **ё/ Үндсэн хөрөнгө ба түүний элэгдэл**

##### **и. Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт**

Үндсэн хөрөнгийг анх өртгөөр нь хүлээн зөвшөөрнө. Үндсэн хөрөнгийн өртөг нь худалдан авсан үнэ, импортын татвар, эргэн төлөгдөхгүй худалдан авалтын татвар болон тухайн үндсэн хөрөнгийг ашиглахад бэлэн болгохтой холбоотой гарсан бусад зардал, мөн хөрөнгийн зүйлсийг барьж байгуулах газар дээрх зүйлсийг нураах, зайлуулах, газрыг сэргээх зэрэг өртгүүд багтдаг.

#### **Элэгдэл**

Элэгдлийг хөрөнгө түүний ирээдүйд авчрах эдийн засгийн үр өгөөжөөс нь хамаарч ашиглагдах жилийнх нь туршид шулуун шугамын аргаар элэгдүүлж, ашиг, алдагдлаар бүртгэдэг. Худалдаж авсан үндсэн хөрөнгийг түүнийг байршуулж, ашиглахад бэлэн болсон үеэс нь дотооддоо барьж байгуулсан хөрөнгийн хувьд тэдгээрийг дуусгавар болгож, үйл ажиллагаа явуулахад бэлэн болсон үеэс нь эхлэн элэгдэл байгуулдаг. Үндсэн хөрөнгийг ашиглахаар тогтоосон хугацаа нь дараах байдалтай байна.

<b>Үндсэн хөрөнгийн ангилал</b>	<b>Ашиглалтын хугацаа (жилээр)</b>
Барилга байгууламж	40 жил
Машин тоног төхөөрөмж	10 жил
Тавилга эд хогшил	10 жил
Компьютер дагалдах хэрэгсэл	3 жил
Бусад үндсэн хөрөнгө	10 жил

#### **ж/ Биет бус хөрөнгө**

Биет шинж чанаргүй, харьцангуй урт хугацаанд ашиглагддаг, өөрийн эзэмшигчиддээ эрх, давуу болон онцгой эрх, өрсөлдөөний давуу талыг олгосон хөрөнгийг биет бус хөрөнгө гэнэ. Биет бус хөрөнгөнд патент, гудвилл, франчайз, зохиогчийн эрх, лиценз, худалдааны тэмдэг, программ хангамж, зохион байгуулалтын зардал зэрэг хөрөнгүүд хамаарагдана. Биет бус хөрөнгийг 20 жилээс илүүгүй хугацаанд ашиглана. Биет бус хөрөнгийг анхны өртгөөр нь бүртгэнэ.

#### **з/ Дансны болон бусад өглөг**

Өр төлбөр нь өнгөрсөн үйл явдлын үр дүнд бусдын өмнө хүлээсэн үүрэг хариуцлага бөгөөд ирээдүйд төлөх бодит өртгөөрөө бүртгэлд тусгагддаг. Өр төлбөрийг богино хугацаат болон урт хугацаат өр төлбөр гэж ангилан балансад тусгана. Зээлээр худалдан авсан бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээнийхээ төлбөрийг борлуулагч тал болон бусад харилцагч этгээдэд төлөх мөнгөн дүнг өглөгөөр тооцож бүртгэлд тусгадаг байна.

#### **и/ Эздийн өмч**

Эздийн өмч буюу капитал нь оруулсан капитал болон олсон капиталын нийлбэр юм. Эздийн өмч нь тухайн байгууллагын нийт хөрөнгийн дүнгээс өр төлбөрийг хассан дүнтэй тэнцүү байна.

**й/ Ногдол ашиг**

Ногдол ашгийг тухайн тайлант үед, эсвэл түүнээс өмнө зарласан бол ногдол ашгийн өр төлбөрөөр бүртгэж, эздийн өмчийг бууруулдаг. Ногдол ашгийг санхүүгийн тайланг батлан гаргахаас өмнө тайлангийн өдрийн байдлаар санал оруулсан эсвэл санал оруулсан ч тайлангийн өдрийн дараагаар зарласан тохиолдолд тайлагнана. Компани нь ногдол ашгийг мөнгөөр, хувьцаагаар, эд хөрөнгөөр хуваарилдаг байна. "Хүрд" ХК нь ногдол ашиг төлсний дараа компани нь төлбөрийн чадвартай байх зарчмыг баримталдаг байна.

**л/ Орлогыг хүлээн зөвшөөрөх**

Бараа, үйлчилгээг мөнгөөр эсвэл мөнгө нэхэмжлэх эрх буюу авлагаар арилжсан үед, мөнгө эсвэл мөнгө нэхэмжлэх эрхийн тогтоосон дүнд шууд хөрвөх боломжтой хөрөнгийг арилжаагаар хүлээн авсан бол орлого хэрэгжих боломжтой гэсэн зарчмаар бараа, бүтээгдэхүүнийг худалдан авагчдад хүлээлгэн өгсөнөөр, ажил үйлчилгээний орлогыг аккреул суурьт үндэслэн тайлант хугацааны туршид хуримтлуулан, хэрэглэгчдэд ажил үйлчилгээ үзүүлж, бараа бүтээгдэхүүнийг худалдан авагчдад шилжүүлж нэхэмжлэх боломжтой болсон үед орлогоор хүлээн зөвшөөрдөг байна. Орлого нь НӨАТ болон бусад татвар хөнгөлөлт, урамшууллыг хассан цэвэр бодит үнэ цэнээр хэмжигддэг.

Хүү, түрээсийн орлого нь байгууллагын хөрөнгийг бусад этгээд ашиглахыг зөвшөөрсөний дүнд бий болсон орлогыг өнгөрсөн хугацаа буюу хөрөнгө ашиглалтаар хүлээн зөвшөөрдөг байна. Мөн үнэ төлбөргүй, хандиваар хүлээн авсан бараа бүтээгдэхүүнийг орлогоор хүлээн зөвшөөрдөг байна.

**м/ Өртөг/ Зардал хүлээн зөвшөөрөлт**

Тайлант хугацаанд хувь нийлүүлэгчид хуваарилснаас бусад шалтгааны улмаас мөнгөний гадагш урсгал хэлбэрээр хөрөнгийг бууруулж, өр төлбөрийг ихэсгэдэг эдийн засгийн өгөөжийн бууралт гарах үед зардлыг хүлээн зөвшөөрдөг.

**• Борлуулалт ба ерөнхий үйл ажиллагааны зардал**

Бүтээгдэхүүн ажил үйлчилгээний өртөгт хамаарахгүй, үйл ажиллагааны явцад гардаг ерөнхий удирдлагын зардлыг зардлын ангиллаар бүртгэнэ. Энэ бүртгэл нь үйл ажиллагаанд ямар төрлийн зардал хэдий хэмжээгээр гарсныг тодорхойлохоос гадна хяналт тавихад чухал ач холбогдолтой байна.

**• Санхүүгийн зардал**

Санхүүгийн зардал нь зээлийн хүүгийн зардал, санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын алдагдлын хасагдуулгаас бүрдэнэ. Хөрөнгийг ашиглах зориулалтаар нь бэлэн болгоход хугацаа шаарддаг хөрөнгийн бүтээн босголт, өргөтгөл, шинэчлэлд хамаарах зээлийн өртгийг тухайн хөрөнгийн өртгийн нэг хэсэг болгон капиталжуулдаг. Бусад бүх зээлийн өртгийг гарсан тайлант хугацааны зардлаар бүртгэдэг.

**н/ Орлогын албан татварын бүртгэл**

Татварын зардал нь тайлант жилийн болон хойшлуулсан татварын зардлын нийлбэрээс бүрдэх бөгөөд орлогын тайланд тусгагддаг. Компанийн татвар нь тайлант жилийн татвар ногдуулах орлогод ногдох балансын өдрөөр хүчинтэй байгаа татварын хувь хэмжээгээр тооцсон бөгөөд өмнөх үеийн татварын өглөг, хойшлуулсан татварын хөрөнгө ба өр төлбөрийг тохируулсан хүлээгдэж буй татварын хөрөнгө эсвэл өглөг байна.

Хойшлогдсон татвар нь санхүүгийн тайлагналын зорилгоор бүртгэсэн хөрөнгө болон өр төлбөрийн дансны үнэ ба татварын тайлагналын зорилгоор бүртгэсэн үнийн зөрүүнээс үүссэн түр зөрүү юм. Хойшлогдсон татварыг тайлагнах өдрөөрх болон цаашид хэрэгжих

хуульд үндэслэн буцаалт хийгдэх түр зөрүүнд хэрэгжихээр хүлээгдэж байгаа татварын хувиар тооцдог. Ирээдүйд татвар ногдуулах ашиг нь татварын түр зөрүүг нөхөхүйц байх тохиолдолд хойшлогдсон татварын хөрөнгийг хүлээн зөвшөөрнө. Хойшлогдсон татварын хөрөнгийг тайлант үе бүрт хянаж холбогдох татварын өгөөжийг хэрэгжүүлэх буюу бууруулдаг.

**o/ Нийгмийн даатгал болон эрүүл мэндийн даатгал**

Монгол улсын хуулийн дагуу Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа компаниуд нь нийгмийн даатгал болон эрүүл мэндийн даатгалыг зохих ёсоор төлөх ба уг зардлыг гарсан тухайн үед нь орлогын тайланд зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

- Тухайн аж ахуйн нэгж нь компани эсвэл түүнтэй холбоотой аж ахуйн нэгжийн аль нэгнийх нь ажилчдын тэтгэвэр тэтгэмжид зориулсан ажил эрхлэлтийн дараах тэтгэмжийн төлөвлөгөө бол;
- (i)-д тодорхойлсон хувь хүн тухайн аж ахуйн нэгжид хяналт тавьдаг эсвэл хамтран хянадаг бол;
- (i)-д тодорхойлсон хувь хүн тухайн аж ахуйн нэгжид мэдэгдэхүйц нөлөөтэй эсвэл уг аж ахуйн нэгж (эсвэл түүний толгой компани)-ийн тэргүүлэх удирдлагын гишүүн бол.
- Компани эсвэл компанийн толгой компанид менежментийн үйлчилгээ үзүүлдэг аж ахуйн нэгж эсвэл группын гишүүн аж ахуй нэгж бол.

*Эдгээр тэмдэглэлүүд нь хавсаргасан санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг бөгөөд тэдгээртэй хамт уншигдана.*

**“ХҮРД” ХК-ИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН  
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

**1. МӨНГӨН ХӨРӨНГӨ**

ХҮРД ХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх мөнгөн хөрөнгө дараах байдалтай байна.

Төрөл	(мянган төгрөг)	
	Өмнөх он	Тайлант он
Касс дахь бэлэн мөнгө	38,029.3	15,909.6
<b>ДҮН</b>	<b>38,029.3</b>	<b>15,909.6</b>
Банкин дахь мөнгө	16,204,887.0	20,772,554.0
<b>ДҮН</b>	<b>16,204,887.0</b>	<b>20,772,554.0</b>
<b>Нийт дүн</b>	<b>16,242,916.3</b>	<b>20,788,463.6</b>

**2. ДАНСНЫ АВЛАГА**

**а. Дансны авлага**

Төрөл	(мянган төгрөг)	
	Өмнөх он	Тайлант он
Дансны авлага	2,180,112.7	2,839,356.2
<b>Нийт дүн</b>	<b>2,180,112.7</b>	<b>2,839,356.2</b>

**б. Татвар, НДШ-ийн авлага**

Төрөл	(мянган төгрөг)	
	Өмнөх он	Тайлант он
НДШ-ийн авлага	4,931.8	6,096.1
Бусад татварын авлага	1,653.2	2,710.2
<b>Нийт дүн</b>	<b>6,585.0</b>	<b>8,806.3</b>

**3. БУСАД САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ**


Төрөл	(мянган төгрөг)	
	Өмнөх он	Тайлант он
Бусад санхүүгийн хөрөнгө	5,880,439.1	2,740,156.3
<b>Нийт дүн</b>	<b>5,880,439.1</b>	<b>2,740,156.3</b>

**4. БАРАА МАТЕРИАЛ**

Төрөл	(мянган төгрөг)	
	Өмнөх он	Тайлант он
Түүхий эд	811,271.2	989,134.1
Дуусаагүй үйлдвэрлэл	332,193.6	320,352.6
Бэлэн бүтээгдэхүүн	113,856.7	149,259.0
Хангамжийн материал	75,813.2	84,154.3
<b>Нийт дүн</b>	<b>1,333,134.7</b>	<b>1,542,900.0</b>

**5. УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ЗАРДАЛ**

Төрөл	(мянган төгрөг)	
	Өмнөх он	Тайлант он
Урьдчилж төлсөн зардал	392,805.3	629,979.0
<b>Нийт дүн</b>	<b>392,805.3</b>	<b>629,979.0</b>





## 6. БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ

Төрөл	(мянган төгрөг)	
	Өмнөх он	Тайлант он
Бусад эргэлтийн хөрөнгө	5,500.0	5,500.0
<b>Нийт дүн</b>	<b>5,500.0</b>	<b>5,500.0</b>

## 7. БИЕТ БОЛОН БИЕТ БУС ХӨРӨНГӨ

## а. Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн төрөл	(мянган төгрөг)		
	Өмнөх он	Нэмэгдсэн	Тайлант он
Барилга, байгууламж	840,049.5	2,401,706.0	3,241,755.5
Машин, тоног төхөөрөмж	1,577,557.2	9,882.0	1,587,439.2
Тээврийн хэрэгсэл	697,527.6	78,777.3	776,304.9
Тавилга эд хогшил	100,175.4	9,483.6	109,659.0
Компьютер, бусад хэрэгсэл	9,303.6	-	9,303.6
Бусад үндсэн хөрөнгө	2,190.8	-	2,190.8
<b>Нийт дүн</b>	<b>3,226,804.1</b>	<b>2,499,848.9</b>	<b>5,726,653.0</b>

## б. Хуримтлагдсан элэгдэл

Үндсэн хөрөнгийн төрөл	(мянган төгрөг)		
	Өмнөх он	Байгуулсан элэгдэл	Тайлант он
Барилга, байгууламж	290,495.1	31,304.7	321,799.8
Машин, тоног төхөөрөмж	803,707.1	143,982.0	947,689.1
Тээврийн хэрэгсэл	349,834.6	-	349,834.6
Тавилга эд хогшил	83,140.1	13,431.4	96,571.5
<b>Нийт дүн</b>	<b>1,527,176.9</b>	<b>188,718.1</b>	<b>1,715,895.0</b>
<b>Үндсэн хөрөнгө (цэвэр) дүн</b>	<b>1,699,627.2</b>		<b>4,010,758.0</b>

## в. Биет бус хөрөнгө

Биет бус хөрөнгийн төрөл	(мянган төгрөг)		
	Өмнөх он	Нэмэгдсэн	Тайлант он
Программ хангамж	1,821.2		1,821.2
<b>Нийт дүн</b>	<b>1,821.2</b>	<b>0.0</b>	<b>1,821.2</b>

## г. Хуримтлагдсан элэгдэл

Биет бус хөрөнгийн төрөл	(мянган төгрөг)		
	Өмнөх он	Тооцсон хорогдуулга	Тайлант он
Программ хангамж	1,542.0	77.1	1,619.1
<b>Нийт дүн</b>	<b>1,542.0</b>	<b>77.1</b>	<b>1,619.1</b>
<b>Биет бус хөрөнгө (цэвэр) дүн</b>	<b>279.2</b>		<b>202.1</b>



## 8. ДАНСНЫ ӨГЛӨГ

## а. Дансны өглөг

Төрөл	(мянган төгрөг)	
	Өмнөх он	Тайлант он
Дансны өглөг	3,151,983.8	3,570,836.2
<b>Нийт дүн</b>	<b>3,151,983.8</b>	<b>3,570,836.2</b>

## б. Татварын өглөг

Төрөл	(мянган төгрөг)	
	Өмнөх он	Тайлант он
ААНОАТ-ын өглөг	169,034.0	18,904.0
НӨАТ-ын өглөг	219,023.9	65,934.5
ХХОАТ-ын өглөг	20,950.3	21,009.7
Бусад татварын өглөг	27,839.4	30,008.1
<b>Нийт дүн</b>	<b>436,847.6</b>	<b>135,856.3</b>

## в. Ногдол ашгийн өглөг

Төрөл	(мянган төгрөг)	
	Өмнөх он	Тайлант он
Ногдол ашгийн өглөг	17,973.5	17,739.1
<b>Нийт дүн</b>	<b>17,973.5</b>	<b>17,739.1</b>

## г. Урьдчилж орсон орлого

Төрөл	(мянган төгрөг)	
	Өмнөх он	Тайлант он
Урьдчилж орсон орлого	1,122,801.8	1,661,315.6
<b>Нийт дүн</b>	<b>1,122,801.8</b>	<b>1,661,315.6</b>

## д. Бусад богино хугацаат өр төлбөр


Төрөл	(мянган төгрөг)	
	Өмнөх он	Тайлант он
Бусад богино хугацаат өр төлбөр	176.4	176.4
<b>Нийт дүн</b>	<b>176.4</b>	<b>176.4</b>

## 9. ЭЗДИЙН ӨМЧ

Төрөл	(мянган төгрөг)	
	Өмнөх он	Тайлант он
Хувийн өмч	1,100,097.8	3,550,668.5
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	164,937.0	164,937.0
Хуримтлагдсан ашиг	21,746,591.8	23,464,592.4
<b>Нийт дүн</b>	<b>23,011,626.6</b>	<b>27,180,197.9</b>

## 10. ОРЛОГО

Төрөл	(мянган төгрөг)			
	Өмнөх он	Тайлант он	Өөрчлөлт %	
Борлуулалтын орлого	9,749,416.1	7,397,906.8	(2,351,509.3)	24.1
Түрээсийн орлого	117,446.1	48,028.2	(69,417.9)	59.1
Хүүгийн орлого	2,635,512.1	2,305,299.6	(330,212.5)	12.5
Бусад орлого	142,082.3	164,050.1	21,967.8	15.5
<b>Орлогын нийт дүн</b>	<b>12,644,456.6</b>	<b>9,915,284.7</b>	<b>(2,729,171.9)</b>	



## 11. БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ӨРТӨГ

Төрөл	(мянган төгрөг)			
	Өмнөх он	Тайлант он	Өөрчлөлт %	
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	6,719,299.6	6,953,893.8	234,594.2	3.5
<b>Орлогын нийт дүн</b>	<b>6,719,299.6</b>	<b>6,953,893.8</b>	<b>234,594.2</b>	<b>3.5</b>

## 12. ЕРӨНХИЙ УДИРДЛАГЫН ЗАРДАЛ

Төрөл	(мянган төгрөг)	
	Тайлант он	Бүтэц %
Ажилчдын цалингийн зардал	215,847.7	41.5
Аж ахуйн нэгжээс төлсөн НДШ-ийн зардал	26,363.6	5.1
Албан татвар, төлбөр хураамжийн зардал	14,427.4	2.8
Томилолтын зардал	39,799.1	7.6
Бичиг хэргийн зардал	11,857.4	2.3
Шуудан холбооны зардал	786.4	0.2
Сургалтын зардал	3,252.7	0.6
Элэгдэл, хорогдлын зардал	69,438.6	13.3
Шатахууны зардал	9,615.8	1.8
Ашиглалтын зардал	66,061.6	12.7
Хүлээн авалтын зардал	4,767.3	0.9
Бусад зардал	58,046.0	11.2
<b>Зардлын нийт дүн</b>	<b>520,263.6</b>	<b>100.0</b>

## 13. БУСАД ЗАРДАЛ

Төрөл	(мянган төгрөг)	
	Өмнөх он	Тайлант он
Бусад зардал	181,916.9	277,795.5
Гадаад валютын ханшийн зөрүүний олз/гарз	270,069.1	-
<b>Нийт дүн</b>	<b>451,986.0</b>	<b>277,795.5</b>

## 14. ОРЛОГЫН ТАТВАРЫН ЗАРДАЛ


Төрөл	(мянган төгрөг)	
	Өмнөх он	Тайлант он
Тайлант үеийн орлогын татварын зардал		255,571.6
<b>Зардлын нийт дүн</b>		<b>255,571.6</b>

## 15. БОЛЗОШГҮЙ ӨР ТӨЛБӨР

Компанид 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр санхүүгийн тайланд тусгагдаагүй өр төлбөр байхгүй бөгөөд тухайн өдрөөр санхүүгийн тайланд илэрхийлсэн өр төлбөрөөс өөр компани бусдын өмнө ямар нэг үүрэг хүлээгээгүй.

## 16. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ

Санхүүгийн тайлангийн өдөр болон аудитын тайлан бэлтгэсэн өдрийн хооронд тохиолдсон болон үйл ажиллагаанд нөлөөлөх томоохон өөрчлөлт, үйл явдал гараагүй болно.



**“ХҮРД” ХУВЬЦААТ КОМПАНИ**

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн тайлан

**УДИРДЛАГАД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ**

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг доор тэмдэглэв.

**Асуудал 1. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар****Бодит байдал**

- ХҮРД ХК нь өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж, дагаж мөрдөөгүй байна.

**Зөвлөмж**

- Цаашид байгууллагын нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын үйл ажиллагааг улам боловсронгуй болгох үүднээс мөн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т зааснаар “...Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана...” гэсэн үүргийг хэрэгжүүлж ажиллах.

**Асуудал 2. Авлага, өглөгийн бүртгэлийн талаар****Бодит байдал**

- 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүү байдлын тайланд тусгагдсан авлага, өглөгийн үлдэгдлийг харилцагч байгууллагуудтай бүрэн тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулж байх.

**Зөвлөмж**

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д зааснаар “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах.

**Асуудал 3. Мөнгөн гүйлгээний тайлангийн талаар****Бодит байдал**

- Мөнгөн гүйлгээний тайлангаа “Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх” зааврын дагуу тайлагнаагүй байна.

**Зөвлөмж**


- Сангийн Сайдын 2017 оны 361 дүгээр тоот тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх” зааврын дагуу тайлангаа бэлтгэх.

**Асуудал 4. Хөрөнгийн тооллогын талаар****Бодит байдал**

- Тайлант хугацааны эцэст компанийн эд хөрөнгийн тооллогын баримтыг холбогдох тушаал шийдвэр, тооллогын комиссын илтгэх хуудасын хамт аудитад ирүүлээгүй байна.

**Зөвлөмж**

- НББ-ын тухай хуулийн 20 дугаар зүйлийн Ерөнхий нягтлан бодогчийн эрх, үүргийн 20.2.6-д заасан “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийж, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үндэсдлийг



баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтын дагуу байгууллагын эд хөрөнгө болон, төлбөрийн тооцооны тооллогыг жилд 2-оос доошгүй удаа, мөнгөн хөрөнгийн тооллогыг сар бүр хийж хэвших.

Цаашид үндсэн хөрөнгийн тооллогыг жилд нэг удаа, хангамж, бараа материал, түүхий эд материалын тооллогыг жилд 2-оос доошгүй удаа, мөнгөн хөрөнгийн тооллогыг сар бүр хийж хэвших.

Тооллого хийхдээ дор дурьдсан баримтуудыг үйлдэж байх. Үүнд:

- Тооллогыг явуулахдаа бараа материал, үндсэн хөрөнгөнд гарсан хөдөлгөөн, өөрчлөлтийг нягтлан бодогчийн дэлгэрэнгүй бүртгэлд тусгасан байдал, техник, технологийн баримт бичгийг бүрдүүлсэн байдал, бараа материалын нэр төрлийн бүртгэл, тайлангаар гарсан үлдэгдлийн бүртгэлтэй тулган шалгаж бүртгэлд тусгаагүй бараа, эд хөрөнгө, бэлэн мөнгийг илрүүлэн тоолж бүртгэж байх.
- Тооллого эхэлсэн дууссан хугацаа, түүний явц, тооллогын явцад гарсан маргаан, зөрчил, түүнийг шийдвэрлэсэн тухай тэмдэглэл үйлдэж тооллогод оролцогчид гарын үсэг зурж баталгаажуулж байх.
- Тооллогод хамрагдвал зохих эд хөрөнгө, бараа материалыг бүрэн тоолуулсан тухай эд хариуцагчийн баталгааг гаргуулж бүртгэл, тэмдэглэлд тусгана.
- Тооллого явуулах ажлын хэсэг нь тооллогын үр дүнгийн талаар тайлан бичиж удирдлагад танилцуулж байх.

Удирдлага нь тооллогын үр дүнгийн талаар сонсож илэрсэн зөрчил дутагдлын дагуу ямар арга хэмжээ авах талаар шийдвэр гаргаж мөрдөж ажиллах.

НББ-ын тухай хуулийн 20 дугаар зүйлийн Ерөнхий нягтлан бодогчийн эрх, үүргийн 20.2.10-т зааснаар “Аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх” хэмээн заасан.

Дээрхи заалтын дагуу зөвлөмжийн биелэлтийн хариуг бидэнд доорхи хаягаар, албан бичгээр ирүүлнэ үү.

Зөвлөмжүүдийг хэрэгжүүлж ажиллана гэдэгт найдаж байна. Та бүхний ажилд амжилт хүсэж байна.

**БЭЛТГЭСЭН:**

**“СҮЛД-АУДИТ” ХХК**

Захирал, Партнер

Аудитор

Туслах аудитор



Ч. ГҮНДБАЯР

Г. ТӨРСАЙХАН

П.ДАВААЖАРГАЛ

**ТАНИЛЦСАН:**

**“ХҮРД” ХК**

Захирал

Ерөнхий нягтлан бодогч



Э.ТЭМҮҮЖИН

Б. СУМЪЯА